

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР /төсөл/

Нэг. Ерөнхий мэдээлэл

Дэлхийн улс орнууд 2030 он хүртэл хэрэгжүүлэх Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд Жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг тусгай зорилт болгон дэвшүүлсэн байдаг. Тиймээс Олон улсын төсөл хөтөлбөрүүд хөгжиж буй улс орнуудад төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэхдээ төслийн үйл ажиллагаанд оролцогчдын хүйсийн тэгш байдал, нас, ажил эрхлэлтийн байдлыг чухалчлан үзэж, тэгш оролцоог хангахыг хичээн ажилладаг. Монгол улсын хувьд ч энэ асуудал Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгалаа олсон байна.

2011 онд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” Монгол улсын хуулийг, 2017 оны 4 дүгээр сард Засгийн газраас “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг тус тус батлан, Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын алба, аймаг орон нутгийн түвшинд Жендэрийн салбар хороо ажилласнаар орон нутагт Жендэрийн тэгш байдлыг хангах нөхцөл бололцоо бүрдэж, хууль эрх зүйн таатай орчин бий болсон.

Үндэсний энэ тогтолцооны үйл ажиллагаа, бодит үр дүн, үр нөлөөг орон нутаг, салбарын түвшинд эрчимжүүлэхийн тулд орон нутаг бүр өөрийн онцлог, хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн Жендэрийн дэд хөтөлбөр, стратегийг боловсруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Үндэсний болон салбаруудын жендэрийн бодлого төлөвлөлттэй сайтар уялдсан орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр нь орон нутгийн түвшинд жендэрийн тэгш байдлыг хангаж, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгэм дэх тэгш оролцоог нэмэгдүүлж, бодлого, төлөвлөлтийг сайжруулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг урагшлуулахад чухал ач холбогдолтой юм.

“ИНБ-уудын сүлжээ” Төрийн бус байгууллагаар Дундговь аймгийн Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээг хийлгүүллээ.

Судалгааны дүнгээс харахад хэлтэс, агентлагийн дарга нар, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчид, иргэдийн хувьд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр, аймгийн салбар хорооны талаар ойлголт тааруу, нийтийн дунд жендэрийн талаархи хэвшмэл ойлголт давамгайлсан, иргэдэд жендэрийн талаархи сургалт, сурталчилгааны ажил төдийлөн хийгдээгүй, төр, ТББ, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоо сул байна.

2017 оны хүн ам зүйн судалгаагаар Дундговь аймаг нийт 46,383 хүн амтай, тэдний 50,2% нь эрэгтэй, 49,8% нь эмэгтэй байгаа бөгөөд хүн амын хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүйсийн харьцаа тэгш байна.

Хөдөлмөрийн насны нийт (30,528) хүн амын 50,3%, ажил хөдөлмөр эрхэлж байгаа нийт (22,620) хүний 51%, албан бус секторт ажиллагсад (2950)-ын 43%-ийг эрэгтэйчүүд эзэлж байгаагаас харахад хөдөлмөрийн насны болон ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүн амын дунд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүйсийн харьцаанд онцын ялгаа байхгүй байна. Харин эдийн засгийн идэвхтэй хүн ам (23,655)-ын 52,6%-ийг, эдийн засгийн идэвхгүй хүн ам (6812)-ын дийлэнхийг буюу 62%-ийг эрэгтэйчүүд эзэлж байгаа юм.

Дээрх дүнгээс харахад эдийн засгийн идэвхгүй хүн амын дийлэнхийг эрэгтэйчүүд эзэлж байгаа хэдий ч ажил хөдөлмөр эрхлэлтийн хувьд жендэрийн ялгаатай байдал байхгүй байгаа юм. Аймгийн хэмжээнд ажилгүй 1035 иргэн байгаагийн дийлэнхийг буюу 68,5%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Аймгийн хэмжээнд өрх толгойлсон 2045 хүн байгаагийн дийлэнх нь буюу 78,5%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол 21,5% нь өрх толгойлсон аавууд байна.

ФБЯ, ганцаарчилсан ярилцлага, асуулгын дүнгээс харахад нийгэм, олон нийт, гэр бүлийн түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо давамгайлж байна.

Тоон судалгааны дүнгээс харахад шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүдийн оролцоо давамгай байгаа бол сургууль, эмнэлэг гээд төрийн үйлчилгээний салбарт эмэгтэйчүүдийн оролцоо давамгайлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд анги, цэцэрлэгийн хүүхдүүдийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн харьцаа ойролцоо байгаа бол 10-12 дугаар ангийн сурагчдын дийлэнхийг охидууд эзэлж байна. Тиймээс цаашид охидууд илүү боловсрол эзэмшиж, тэдний нийгэм дэх оролцоо сайн байх төлөвтэй байгаа бол тэр хэмжээгээр эрэгтэй хүүхдүүдийн нийгэм дэх оролцоо ирээдүйд буурах хандлага байж болох юм.

Эцэг эхчүүд ихэнхдээ охидууддаа боловсрол эзэмшүүлж, эрэгтэй хүүхдүүдээ мал дээр гаргах, ажил хөдөлмөр эрхлүүлэх хандлага сүүлийн жилүүдэд үргэлжилж байгаа хэвээрээ байна. Тиймээс эрэгтэйчүүдийн боловсрол эмэгтэйчүүдийнхээс доогуур түвшинд очих, түүнээс болж гэр бүл тогтворгүй болох сөрөг талууд нийгэмд байсаар байна. Эрэгтэй хүүхдүүдээ мал дээр гаргах хандлага давамгайлснаас болж сүүлийн жилүүдэд хөдөөд эмэгтэйчүүдийн тоо цөөрч, малчин залуучууд төвөөс эхнэр авч, айл болох байдал нэмэгдэж байгаа ба энэ нь гэр бүлийн тогтвортой байдалд муугаар нөлөөлж байгаа ажээ.

Малчин залуучуудын хувьд хүүхдээ сургууль, цэцэрлэгт оруулахын тулд эхнэрээ төв дээр суулгаснаас болж, 2 тусдаа амьдрах бэрхшээл тулгамдаж байна. Энэ нь хөдөөд малчин залуучуудын хувьд архидалтыг нэмэгдүүлж, гэр бүлийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар нас барж байгаа хүмүүсийн олонх нь эрэгтэйчүүд байна. Хүн амын тоогоор эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүйсийн тооны харьцаанд онцын ялгаа байхгүй боловч тэтгэврийн насны иргэдийн дийлэнх нь буюу 63% эмэгтэйчүүд байна. Тиймээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс бага байгаа учраас тэдний наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгцээтэй юм.

Халдварт өвчний гаралт 2017 онд эрэгтэйчүүдийн дунд илүү байсан бол 2018 онд эсрэгээрээ эмэгтэйчүүд илүү өвчилсөн байна. Сүрьеэ өвчний гаралт 2018 онд буурсан бөгөөд уг өвчнээр эрэгтэйчүүд илүү өвчилжээ.

Хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчин боловсронгуй болж, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр ахиц, дэвшил гарч байгаа боловч хууль хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх, санхүүжилтийг хүрэлцээтэй хуваарилах, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал байсаар байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх зорилт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсрууллаа.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, эмэгтэй, эрэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангах, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бүх түвшний бодлого, үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилт

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн албаны чадавхыг бэхжүүлэх
2. Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөх чиглэлээр бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах
3. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх
4. Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
5. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

2.3. Хөтөлбөрийн хугацаа

Хөтөлбөрийг 2018-2022 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн албаны чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1.1 Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг сайжруулах, манлайллыг бий болгох чиглэлээр чадавхижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, сургагч багш, зөвлөх бэлтгэх

3.1.2 Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах

3.1.3 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, салбар хорооны мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг эрчимжүүлэх

3.1.4 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийг бодлого төлөвлөлтөд тусгах

3.1.5 Аймаг, сумын гэр бүл, хүүхэд, залуучууд, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах, жендэрийн асуудлаар мэргэшүүлэх

3.1.6 Төрийн болон төсөвт байгууллагын нийт ажилчдын дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэх /Хөдөлмөрийн тухай хуулийн 101.1 дэх заалтыг хэрэгжүүлэх болон сургуулийн өмнөх боловсролын байгууллага зэрэг байгууллагын ажил, үйлчилгээний онцлогоос хамаарч нэг хүйсийн хүнийг сонгох асуудал үл хамаарна./

3.1.7 Салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээлэлтэй болох, дүн шинжилгээ хийдэг байх

3.2 Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөх чиглэлээр бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2.1 Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх нөлөөлөл, гэгээрэл сурталчилгааны ажлыг хийх, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх

3.2.2 Жендэрийн талаарх шаталсан сургалтыг бүх шатны удирдах албан тушаалтан, ААН-ийн удирдлагууд, албан хаагчдыг оролцуулан тогтмол зохион байгуулах

3.2.3 Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтын байдал, түүнд нөлөөлж байгаа эрсдэлт зан үйлийг өөрчлөх, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх

3.2.4 Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн орчин дахь эхнэр, нөхрийн тэгш оролцоог хангах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хүүхдийн хөгжил төлөвшил, хандлагыг сайжруулахад төрийн бус байгууллагатай хамтран ажиллах

3.2.5 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр гарын авлага материалтай болж, сургалт тогтмол зохион байгуулах

3.2.6 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан ААН, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, урамшуулах

3.3. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3.1 Орон нутгийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх бодлогын хүрээнд их, дээд сургуульд элсэн суралцаж байгаа хүүхдүүдийн хүйсийн харьцаанд дүн шинжилгээ хийж, эцэг эхчүүдийн жендэрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх

3.3.2 Эрэгтэй хүүхдүүдийг багш, эмч, сувилагч мэргэжлээр сургах, охидуудыг инженер мэргэжилтэй болгох аймгийн бодлого гарган хэрэгжүүлэх

3.3.3 Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн болон сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетыг ажиллуулж, хүний нөөц, техник тоног төхөөрөмжөөр хангах

3.3.4 Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дунд зонхилон тохиолдож байгаа нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа өвчлөлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

3.3.5 Эрүүл мэнд, нөхөн үржихүй, ялангуяа бэлгийн боловсрол олгох сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрөөр заадаг болох

3.3.6 Эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт, буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулж, эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн эрэгтэйчүүдийн ололт, амжилтыг олон нийтэд сурталчилах, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх, ажил хөдөлмөр эрхлүүлэх бодлого гарган ажиллах

3.3.7 Сургуулиудыг дотуур байртай болгон тохижилтыг гэрийн нөхцөлд ойртуулж, залуу малчин өрхүүдийн хүүхдүүдийг дотуур байранд тохь тухтай амьдруулах боломжоор хангахад анхаарах

3.3.8 Өрх толгойлсон олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны түвшингээс доогуур орлоготой эцэг, эхчүүдийг дэмжихэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх

3.3.9 Төрийн байгууллагуудын зүгээс иргэд, олон нийт рүү чиглэсэн бүхий л үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцогчдыг хүйс, насны бүлгээр нь бүртгэлжүүлж, дүн шинжилгээ хийж ажиллах

3.4 Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4.1 Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Хүний эрхийн үндэсний комисс болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөл, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах

3.4.2 Төр, хувийн хэвшлийн байгууллагууд, аж ахуйн нэгжийн дотоод журамд хүчирхийлэл, бэлгийн дарамт зэргээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих асуудлыг тусгуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах

3.4.3 Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг тогтмолжуулж, санхүүжилтын дэмжлэг үзүүлэх

3.4.4 Охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлж, эцэг, эх, сургууль, хамт олны хяналтыг сайжруулах

3.4.5 Өсвөр үе, залуучуудын дунд гэр бүлийн үнэт зүйлсийн талаарх ойлголт, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг эцэг эх, олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах

3.5 Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.5.1 Улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд иргэдийг төлөөлөх эмэгтэй төлөөлөгчийн тоог нэмэгдүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх

3.5.2 Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ.

4.1.1. Жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдсөн байна.

4.1.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт хангагдана.

4.1.3. Жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд тусгагдсан байна.

4.1.4. Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байр тогтмол ажиллагаатай болсон байна.

4.1.5 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэн байна.

4.2 Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2018 он/	Хүрэх түвшин
1	Дотоод журмандаа хүчирхийлэл, бэлгийн дарамт зэргээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих асуудлыг тусгасан байгууллагын тоо	Хувь	0	50
2	Эрэгтэйчүүдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг нэгж	Тоо	0	3
3	Жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ хийсэн байгууллага	Тоо	0	5
4	Их, дээд сургуульд элсэн орогчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь	Хувь	?	40
5	Жендэрийн сургалтанд хамрагдсан удирдах ажилтан	Хувь	10	100
6	Жендэрийн сургалтанд хамрагдсан төрийн албан хаагч	Хувь	10	70
7	Шийдвэр гаргах түвшинд оролцогч эмэгтэйчүүд	Хувь	50	50

Тав. Хөтөлбөрийн санхүүжилтын эх үүсвэр

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

5.1.2. Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

5.1.3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж

5.1.4. Бусад эх үүсвэр

Эх сурвалж

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2017-2021/
3. Говийн бүсийн суралт, семинарт оролцогчдоос гаргасан зөвлөмж
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги
6. “Дундговь аймаг дахь жендэрийн тэгш байдал” ИНБ-ын сүлжээ ТББ-аас хийсэн нөхцөл байдлын үнэлгээ